

**2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 11 дүгээр сарын 29-ний “Лхагва” гарагт e-doc системээр албан бичгээр ирүүлж, (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

| № | Өгсөн үүрэг даалгавар | Хариуцах эзэн |
|---|---|--|
| НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР | | |
| 1 | Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, нийслэл, дүүргийн дунд хугацааны бодлогын болон төлөвлөлтийн баримт бичгүүд мөн шинээр батлагдах Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиудын хүрээнд Улаанбаатар хотын салбаруудын бодлогын баримт бичгийг боловсруулах хүрээнд хүргүүлсэн саналуудыг хууль тогтоомж, баримт бичгүүдэд тусгагдсан эсэхийг тодруулж ажиллах. | ТЗУХ |
| 2 | Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэл тооллогыг зохион байгуулахтай холбогдуулан бэлтгэлийг сайтар ханган, өмчийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, шаардлага хангахгүй өмчийг бүртгэлээс хасуулах зэрэг асуудлыг шийдвэрлүүлэн ажиллах. | Хэлтэс, албад, ААНБ-ууд |
| 3 | Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулсантай холбогдуулан нийслэлийн төсвөөс санхүүжиж буй ОНӨААТҮГ-уудыг хувийн хэвшилд шилжүүлэх чиглэлээр санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан ба энэ хүрээнд дүүргээс хүргүүлсэн саналуудын талаар тодруулж ажиллах. | ЗДТГ, ТХҮХ |
| 4 | Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 12 дугаар сардаа багтаан эцэслэх тул холбогдох саналыг хүргүүлэх. | ЗДТГ, ТХҮХ |
| 5 | Нийслэлийн 2024 оны төсөв батлагдахад дүүргийн хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, 2024 оны 01 дүгээр сардаа зарлаж дуусгах, 02 дугаар сарын 01-ны дотор гэрээ байгуулах, түүнчлэн дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг нийт байгууллагууд дээд шатны байгууллагатай уялдаатай байж төсөв хөрөнгө шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллах. | СТСХ, ХААА, ААНБ-ууд |
| ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР | | |
| 6 | Хууль журмын хүрээнд ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэн урамшуулал олгох, хариуцлага тооцох хүрээнд ЗДО-оор ахлуулсан Ажлын хэсэг дүүргийн ААНБ-уудын дарга, захирал, эрхлэгч нарын ажлыг 2024.12.04-08-ны хооронд үнэлж дүгнэх. | ЗДО Б.Болормаа, ЗДТГ |
| 7 | 2023 оны 12 дугаар сарын дунд үеэр дүүргийн 1, 2 дугаар хороонд “Мөсөн хотхон” байгуулах ажлын зураг гаргаж танилцуулан, бэлтгэл ажлыг яаралтай хангаж ажиллах. | Багахангай тохижилт, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд |
| 8 | Дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт он дамжин баригдаж буй Спорт залны барилгын ажил ирэх онд ашиглалтад орохтой холбогдуулан Улс, нийслэлийн төсөв хэлэлцэж буй энэ үед тус | НХХ, БТСХ |

| | | |
|----|--|--------------------------------|
| | заланд шаардлагатай тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэх хүрээнд холбогдох байгууллагад уламжилж, асуудлаа танилцуулах. | |
| 9 | Байгаль, цаг агаарын нөхцөл байдалтай холбогдуулан иргэд, зорчигч, тээвэрлэгч, малчдыг болзошгүй аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх хүрээнд олон нийтийн сүлжээ, цахим группээр мэдээ мэдээллийг хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах. | ОБХ, ТХҮХ, ХААТ |
| 10 | 2024.01.01-ний өдөр дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдах “Нар харах ёслол”-ын арга хэмжээний хүрээнд Ажлын хэсэг байгуулан холбогдох арга хэмжээ, үйл ажиллагааны бэлтгэл ажлыг сайтар ханган ажиллах. | ЗДО Б.Болормаа, ЗДТГ, ААНБ-ууд |
| 11 | СӨХ-ны үйл ажиллагааг сайжруулах хүрээнд холбогдох чиглэлийг өгч, ажлын гүйцэтгэл, чанарт анхаарах. | ТХҮХ, |

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР